



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2012 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 22

Мандалговь

Автомашиныг худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дугаар зүйлийн 31.1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журмын 3 дугаар зүйлийн 3.1“в” 3.2.6-гийн “а” заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ НЬ:**

1. Дундговь аймгийн Адаацаг сумын Эрүүл мэндийн төвд ашиглагдаж байгаа 5366 УБИ улсын дугаартай УАЗ-22069 пургон машиныг байгууллагын санал Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт зэрэг баримт бичгийг үндэслэн ажлын шаардлага хангахгүй болсон тул худалдахыг зөвшөөрсүгэй.
2. 2007 онд ашиглалтад орсон 53-66 УБИ улсын дугаартай УАЗ 22069 пургон маркын автомашиныг 2,0 сая төгрөгөөр худалдах доод үнийг тогтоон дуудлагаар худалдсугай.
3. Автомашиныг хүлээн авч дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу явуулахыг Орон нутгийн өмчийн алба /Ш.Батсүх/-д даалгасугай.

ДАРГА



С.БУДЖАВ